1.0 Багшийн журналд ажиллах дараалал

БСМС ашиглан “Багшийн журнал” хөтлөх


БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ

БСК ДУГААР

БАГШИЙН ЖУРНАЛ

III-XII анги

Аймаг (нийслэл): .....

Сум (дүүрэг): .....

Сургууль: .....

Анги бүлэг: .....

Багшийн овог, нэр: .....

20..... - 20.. .... оны хичээлийн жил




1
БҮЛЭГ СЭДВИЙН БҮРТГЭЛ
Тухайн хичээлийн хувьд сургуулийн ЗАН - ээс батлсан хичээлийн бүлэг сэдвийн жагсаалтыг бүртгэж оруулна.
Суралцагчдын эзэмшвэл зохих мэдлэг, чадварыг үнэлэх шалгуурыудыг бүлэг сэдэв бүрээр багш тодорхойлж өгнө.
Мөн бүлэг сэдвийг хүргэхэд тулгарсан хүндрэл, цаашид ашиглагдах шинэлэг арга барилын талаар багш дүгнэлт бүртгэнэ.
2
БАГШИЙН ТЭМДЭГЛЭЛ
Эзлэхүүн хичээлээр үзсэн үндсэн үйл ажиллагаа, гэрийн даалгавар мөн цаашид анхаарах асуудлыг товч бүртгэнэ.
Эзлэхүүн хичээлийн үйл ажиллагаа бүр нэг бүлэг сэдвийн хүрээнд явагдана.
Багшийн тэмдэглэлийн бүртгэлийг эзлэхүүн хичээлийн төлөвлөгөөний дагуу урьдчилан бүртгэх боломжтой.
3
ИРЦИЙН БҮРТГЭЛ
Урьдчилан төлөвлөж бүртгэсэн багшийн тэмдэглэлээс сонгосоны дагуу ирц бүртгэх боломжтой болно.
Ирцийн бүртгэл болон эзлэхүүн хичээлийн үйл ажиллагааг оруулсан тохиолдолд багшийн журналын ИРЦИЙН БҮРТГЭЛ, БАГШИЙН ТЭМДЭГЛЭЛ хуудсыг хэвлэх боломжтой.
4
БҮЛЭГ СЭДВИЙН ҮНЭЛГЭЭ БҮРТГЭХ
Суралцагчийн мэдлэг, чадварыг үнэлэх үнэлгээг бүлэг сэдэв бүрийн хувьд багш бүртгэнэ. Жишээ нь: *"Тоо тоолол" бүлэг сэдвийн хүрээнд 2018-11-05-ны өдөр сорил авах.*
Бүлэг сэдвийн үнэлгээг урьдчилан төлөвлөн бүртгэх боломжтой бөгөөд эцэг эхийн системээс үнэлгээний талаарх мэдээллийг авч болно. Өөрөөр хэлбэл дараагийн бүлэг сэдвийг үнэлэх хугацаа, дэлгэрэнгүй тайлбарыг эцэг эхэд хүргэх боломж нээгдэж байна.
5
СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ БҮРТГЭХ
Суралцагч бүрийн хувд үнэлгээ болон тайлбарыг бүртгэнэ.
Эцэг, эхийн системээр дамжуулж суралцагчийн бүлэг сэдвийн үнэлгээ буюу түвшин, түүнд өгсөн багшийн тайлбарыг хүргэх боломжтой.
Дээрх бүртгэлийг хийснээр багшийн журналын ҮНЭЛГЭЭ-1 гэсэн хуудас хэвлэгдэх боломжтой.
6
СУРАЛЦАГЧИЙН ДҮН БҮРТГЭХ
Хагас жил болон жилийн эцэст хичээлийн дүнг хичээлийн багш бүртгэнэ.
ҮНЭЛГЭЭ -2 Тун удахгүй системд шинэчлэгдэн байршина.